СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2025 IV

www.ubstat.mn

Улаанбаатар хот
2025 он

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII … г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
* урьдчилсан гүйцэтгэл
** дахин

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

МЭДЭЭЛЭЛ

МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ

АГУУЛГА

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ДҮҮРГЭЭР		4
I	ЭРҮҮЛ МЭНД	5-8
II	ГЭМТ ХЭРЭГ	9-13
III	ТӨСӨВ	14-17
IV	ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	18-23
V	ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ	24-29

Хүснэгт 1. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, дүүргээр

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2021 I-IV	2022 I-IV	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV
Шинээр төрсөн хүүхэд		Хүн	12 170 ↓6.7	10 199 ↓16.2	11 580 ↑13.5	10 347 ↓10.6	9 657 ↓6.7
Халдварт өвчнөөр өвчлөгчид		Хүн	20 454 ↑3.5**	145 134 ↑7.1**	6 179 ↓95.7	5 972 ↓3.4	7 147 ↑19.7
Бүртгэгдсэн гэмт хэрэг		Тоо	4 935 ↓25.9	9 746 ↑2.0**	9 678 ↓0.7	9 058 ↓3.4	13 119 ↑44.8
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)		Хувь	3.4↑3.9	2.9↓0.5	1.4↓1.5	0.6 ↓0.8	0.3↓0.3
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	Төгрөг	2 850↑2.4	3 042 ↑6.7	3 496 ↑14.9	3 377 ↓3.4	3 542 ↑4.9
	Юань (БНХАУ)	Төгрөг	437 ↑11.2	473 ↑8.2	508↑7.4	466 ↓8.3	485↑4.1
	Рубль (ОХУ)	Төгрөг	37↑1.0	38 ↑2.7	43↑13.2	36↓16.3	42 ↑16.7
Нийслэлийн төсвийн орлого		Тэрбум төгрөг	336.6 ↑20.9	423.2 ↑25.7	613.4 ↑44.9	958.3 ↑56.2	1 137.8 ↑18.7
Нийслэлийн төсвийн зарлага		Тэрбум төгрөг	328.5 ↓8.5	354.6 ↑7.9	539.5 ↑52.1	718.4 ↑33.2	1 363.8 ↑89.8
Агаарын дундаж температур		^{0}C	3.1	3.4	-3.9	4.9	4.7

Хүснэгт 2. НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 I-IV					2025 I-IV				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	349	Баянгол	8 578	Налайх	59	357	Баянгол	8 797	Налайх	59
			Чингэлтэй	1 526	Багануур	47		Чингэлтэй	1 490	Багануур	47
			Сүхбаатар	679	Багахангай	32		Сүхбаатар	688	Багахангай	32
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	13	Багахангай	29	Баянзүрх	7	16	Багануур	29	Баянзүрх	10
			Багануур	15	Чингэлтэй	6		Сүхбаатар	19	Чингэлтэй	9
			Сонгино-хайрхан	13	Налайх	4		Налайх	18	Багахангай	-
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	37	Баянзүрх	43	Чингэлтэй	25	43	Багануур	42	Хан-Уул	26
			Сүхбаатар	31	Сонгино-хайрхан	24		Баянзүрх	39	Налайх	18
			Баянгол	30	Багахангай	5		Баянгол	34	Багахангай	13
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	67	Баянгол	104	Багахангай	84	83	Баянзүрх	123	Налайх	91
			Сүхбаатар	102	Налайх	75		Сүхбаатар	121	Багахангай	80
			Чингэлтэй	102	Багануур	29		Хан-Уул	120	Багануур	26
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	73	Сонгино-хайрхан	106	Налайх	42	119	Сүхбаатар	200	Сонгино-хайрхан	78
			Баянгол	85	Багахангай	30		Чингэлтэй	140	Налайх	41
			Чингэлтэй	83	Багануур	27		Баянгол	133	Багахангай	29

ЭРҮҮЛ МЭНД
2025 оны эхний 4 сард

Амаржсан эх

2024 I-IV	1 857	
2025 I-IV	1 715	7.6% ↓

Шинээр төрсөн хүүхэд

2024 I-IV	1 864	
2025 I-IV	1 724	7.5% ↓

Нийт халдварт өвчнөөр өвчлөгсөд

2024 I-IV	819	
2025 I-IV	986	20.4% ↑

0-1 насны хүүхдийн эндэгдэл	2024 I-IV	24
	2025 I-IV	26
1-5 насны хүүхдийн эндэгдэл	2024 I-IV	3
	2025 I-IV	3

ЭРҮҮЛ МЭНД

I-IV/2025 Тархаасан: 2025 оны 5 дугаар сарын 15

Дүүргийн хэмжээнд 2025 оны эхний 4 сард 986 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 167 (20.4%) хүнээр өссөн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 43 (4.4%) цусан суулга, 20 (2.03%) улаан эсэргэнэ, 256 (26%) салхин цэцэг, 33 (3.4%) гар хөл, амны өвчин, 92(9.3%) улаан бурхан, 150(15.2%) тэмбүү, 92 (9.3%) заг хүйтэн, 92 (9.3%) шинээр илэрсэн сүрьеэ, 101 (10.3%) трихомониаз өвчлөгчид тус тус эзэлж байна. Халдварт өвчнийг өмнөх онтой харьцуулахад цусан суулга 34 (44.2%), улаан эсэргэнэ 12 (37.5%), гахайн хавдар 17(89.5%), гар хөл амны өвчин 31 (48.4), шинэ илэрсэн сүрьеэ 2 (2.1%) тус тус буурсан байна. Харин салхинцэцэг 37(16.9%), гепатит 2 (28.6%), ёлом 4 (44.4%), тэмбүү 16 (11.9%), заг хүйтэн 29 (46%), трихомониаз 14 (16.1%), тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 3. ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 4 САРД

Үзүүлэлт	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	2025 I-IV / 2024 I-IV	
	тоо			Дүн	Хувь
НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН	**638**	**819**	**986**	**167**	**20.4**
Цусан суулга	53	77	43	-34	-44.2
Улаан эсэргэнэ	6	32	20	-12	-37.5
Менингит	2	0	0	0	0
Гепатит	6	7	9	2	28.6
Салхинцэцэг	199	219	256	37	16.9
Гахайн хавдар	1	19	2	-17	-89.5
Сальмонеллёз	4	10	10	0	0.0
Ёлом	1	9	13	4	44.4
ГХА өвчин	73	64	33	-31	-48.4
Улаан бурхан	0	0	92	92	0
Хоолны хордлого	0	4	46	42	10.5[1]
Эритема B08.3	0	0	23	23	0
Тэмбүү	97	134	150	16	11.9
Заг хүйтэн	35	63	92	29	46.0
Шинэ илэрсэн сүрьеэ	90	94	92	-2	-2.1
Трихомониаз	70	87	101	14	16.1

1- дахин их

ЗУРАГ 1. ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 4 САРД



2025 оны эхний 4 -р сард 1715 эхээс 1724 хүүхэд мэндэлсэн байна. Өнгөрсөн оны мөн үед 1857 эхээс 1864 хүүхэд мэндэлж байжээ. Тайлант хугацаанд 0-1 насны хүүхдийн эндэгдэл 26 гарсан нь өмнөх оны мөн үеэс 2(8.3%) өссөн байна. 1-5 насны хүүхдийн эндэгдэл 3 гарсан нь өмнөх оны мөн үетэй ижил байна.

ХҮСНЭГТ 4. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 4 САРД

Үзүүлэлт	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	2025 I-IV / 2024 I-IV	
	тоо			Дүн	Хувь
Амаржсан эхийн тоо	2 114	1 857	1 715	-142	-7.6
Амьд төрсөн хүүхэд	2 128	1 864	1 724	-140	-7.5
Нийт нас баралт	579	577	549	-28	-4.9
0-1 насны хүүхдийн эндэгдэл	34	24	26	2	8.3
1-5 насны хүүхдийн эндэгдэл	2	3	3	0	0.0
Төрөхийн улмаас эндсэн эх	0	2	0	-2	-100.0

Эмнэлгийн байгууллагууд 2025 оны эхний 4 -р сарын байдлаар 440099 үзлэг хийсний 151598 (34.4%) нь урьдчилан сэргийлэх, 106017 (24.09%) нь гэрийн үзлэг байна. Тайлант хугацаанд 138 эх шинээр жирэмсний хяналтад орсноос 6 (4.4%) нь цус багадалттай, 4 (2.9%) тэмбүү, 4 (2.9%) нь трихомониазийн өвчлөл эерэг гарсан байна. Шинээр хяналтанд орсон жирэмсэн эхчүүдийн 126 (91.3%) нь жирэмсний эхний 3 сартайдаа хяналтад орсон байна. 2025 оны эхний 4 -р сард артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт 43245 хүн хамрагдсанаас 26436 (61.1%) эмэгтэйчүүд байна. Үүнээс давтан үзлэгт 1204 (2.8%) нь хамрагдсан байна. Чихрийн шижин хэв шинж 2-ын эрт илрүүлгийн үзлэгт 29089 хүн хамрагдсанаас 17468 (60%) нь эмэгтэйчүүд байна. Тайлант хугацаанд эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан нийт хүний 12743 (52.8%) нь артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт, 9015 (37.4%) нь чихрийн шижин хэв шинж 2-ын эрт илрүүлгийн үзлэгт, 2373 (9.8%) нь элэгний хорт хавдрын эрт илрүүлэгийн үзлэгт тус тус хамрагдсан байна.Тайлант хугацаанд 0-5 насны 2632 хүүхдийн өсөлтийн үндсэн үзүүлэлтийг шалгахад 0-5 насны хүүхдүүдийн 23 (0.8%) нь туранхай, 22 (0.8%) нь тураалтай, 24 (0.9%) нь өсөлтийн хоцрогдолтой хүүхэд байсан байна. Амбулатороор үйлчлүүлсэн 0-5 насны 2094 хүүхэд А амин дэм, 6369 хүүхэд Д амин дэм тус тус уусан байна.

Аргачлалын тайлбар:

Нярайн эндэгдлийн түвшин: (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин: (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин: (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа: (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайгаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйн судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Амьгүй төрөлт: Жирэмсний 22 долоо хоног ба түүнээс хойших хугацаанд, 500 граммаас дээш жинтэй төрсөн нярайд амьдын шинж тэмдгийн аль нь ч (зүрхний цохилт, судасны лугшилт, булчингийн хөдөлгөөн) илрэхгүй байгааг хэлнэ.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

Эх үүсвэр:

Дүүргийн эрүүл мэндийн төв

Ангилал, код:

Өвчний олон улсын ангилал /ICD-10/

Мэдээлэл авах холбоос:

http://www.1212.mn/

Дараагийн мэдээ тархаах хугацаа:

2026 оны 1 дүгээр сарын 16

ГЭМТ ХЭРЭГ

2025 оны эхний 4 сард

Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

2024 I-IV	2025 I-IV	
1 445	1 770	22.5% ↑

Дүүргээр



Гэмт хэргийн улмаас

Хохирсон хүн	Гэмтсэн хүн	Нас барсан хүн
1 680	435	63

ГЭМТ ХЭРЭГ

Сонгинохайрхан дүүрэгт 2025 оны эхний 4 сард 1770 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 325 (22.5%) хэргээр өссөн байна.

Нийт гэмт хэргийн 1465 (82.8%) нь хөнгөн гэмт хэрэг бол 305 (17.2%) нь хүнд гэмт хэрэг байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 2.8 хувийг хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг, 0.3 хувийг хүнийг алах, 21.9 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 1.1 хувийг хүний халдашгүй эрх чөлөөтэй байх эрхийн эсрэг, 2.3 хувийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 24.0 хувийг хулгайлах, 4.6 хувийг дээрэмдэх, 25.7 хувийг залилах, 6.4 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг, 10.9 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 5. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр жил бүрийн эхний 4 сард

Төрөл		2024 I-IV	2025 I-IV	2024 I-IV / 2025 I-IV		Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		тоо		Дүн	Хувь	
Нийт гэмт хэрэг		**1445**	**1770**	**325**	**22.5**	**100**
Гэмт хэргийн төрөл	Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг	20	49	29	2.5[1]	2.8
	Хүнийг алах	8	6	-2	-25.0	0.3
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	384	387	3	0.8	21.9
	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	34	41	7	20.6	2.3
	Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	12	20	8	66.7	1.1
	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	2	0	-2	-100.0	-
	Хулгайлах	327	424	97	29.7	24.0
	Дээрэмдэх	40	81	41	2.0[1]	4.6
	Залилах	390	455	65	16.7	25.7
	ХАБТХАЖЭ[2]	51	114	63	2.2[1]	6.4
	Бусад	177	193	16	9.0	10.9

[1]-дахин их
[2]-Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг

Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралтыг өмнөх онтой харьцуулбал хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг 29 (2.5 дахин их), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг (ХАБТХАЖЭ[2]) гэмт хэрэг 63 (2.2 дахин их), дээрэмдэх гэмт хэрэг 41 (2.0 дахин их), хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 8 (66.7%), хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт 7 (20.6%), хулгайлах гэмт хэрэг 97 (29.7%), залилах гэмт хэрэг 65 (16.7%), бусад гэмт хэрэг 16 (9.0%), Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3 (0.8%) тус тус өссөн үзүүлэлттэй байна. Харин хүнийг алах гэмт хэрэг 2 (25.0%) буурсан үзүүлэлттэй байна.

ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТ

2025 оны эхний 4 сард гэмт хэргийн илрүүлэлтийн хувь Улсын хэмжээнд 23.7%, Нийслэлийн хэмжээнд 20.3% байгаа бол Сонгинохайрхан дүүрэгт 27.3% байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.2% буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6. **ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТИЙН ХУВЬ, хэлтсээр, жил бүрийн эхний 4 сард**

Хэлтэс	2024 I-IV	2025I-IV	2024 I-IV / 2025 I-IV
	Хувь		
Нийт илрүүлэлт	**36.5**	**27.3**	**-9.2**
СХДЦХ-1	30.4	24.8	-5.6
СХДЦХ-2	43.0	27.7	-15.3
СХДЦХ-3	44.1	31.8	-12.3

Цагдаагийн 1 дүгээр хэлтэст гэмт хэргийн илүүрэлт 24.8 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар, Цагдаагийн 2 дугаар хэлтэст гэмт хэргийн илэрүүлэлт 27.7 хувь байгаа нь 15.3 хувиар, Цагдаагийн 3 дугаар хэлтэст гэмт хэргийн илэрүүлэлт 31.8 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 12.3 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 2. **БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хэлтсээр, 2025 оны эхний 4 сард**



Нийт бүртгэгдсэн 1770 гэмт хэргийн 877 (49.5%) цагдаагийн 1 дүгээр хэлтэст, 447 (25.3%) цагдаагийн 2 дугаар хэлтэст, 446 (25.2%) цагдаагийн 3 дугааар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна

Хүснэгт 7. **ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ, хэлтсээр, жил бүрийн эхний 4 сард**

Хэлтэс	2024 I-IV	2025 I-IV	2024 I-IV / 2025 I-IV		Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
	тоо		Дүн	Хувь	
Нийт зөрчил	**18 310**	**17 288**	**-1 022**	**-5.6**	**100.0**
СХДЦХ-1	6 737	7 614	877	13.0	44.1
СХДЦХ-2	5 665	3 288	-2 377	-42.0	19.0
СХДЦХ-3	5 908	6 386	478	8.1	36.9

Дүүргийн хэмжээнд 2025 оны эхний 4 сард 17288 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1022 (-5.6%) зөрчлөөр буурсан үзүүлэлттэй байна. Зөрчил гаргасан 16313 иргэн, 42 хуулийн этгээдийг мөнгөн торгуулиар торгож, 546 хүнийг баривчлах шийтгэл оногдуулсан байна. Нийт бүртгэгдсэн зөрчлийн 7614 (44.1%) нь цагдаагийн дүгээрl хэлтэст, 3288 (19.0%) нь цагдаагийн II дугаар хэлтэст, 6386 (36.9%) нь цагдаагийн III дугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

Зураг 3. **БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, 2025 оны эхний 4 сард**



2025 оны эхний 4 сард дүүргийн 39 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 11 (0.6%) гэмт хэрэг гарсан нь хамгийн бага байсан бол хамгийн их нь 103 (5.8%) 29 дүгээр хороонд бшртгэгдсэн байна.

2025 оны эхний 4 сард 10, 14, 17, 19, 26, 28, 32 дугаар хороодод бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 6.4 хувиас 23.7 хувь хүртэл буурсан эерэг үзүүлэлттэй бол 5, 31 дүгээр хороодод өмнөх оны мөн үетэй ижил үзүүлэлттэй байна. Харин бусад хороодод 2.9 хувиас 3.2 дахин өссөн сөрөг үзүүлэлттэй байна.

Хүснэгт 8. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор, жил бүрийн эхний 4 сард

Хороо	Гэмт хэргийн тоо			2024 I-IV / 2025 I-IV		Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	Тоо	Хувь	
1-р хороо	28	29	41	12	41.4	2.3
2-р хороо	35	28	46	18	64.3	2.6
3-р хороо	22	25	26	1	4	1.5
4-р хороо	42	34	44	10	29.4	2.5
5-р хороо	45	20	20	0	0	1.1
6-р хороо	59	37	47	10	27	2.7
7-р хороо	27	23	48	25	2.1[1]	2.7
8-р хороо	17	26	41	15	57.7	2.3
9-р хороо	56	19	30	11	57.9	1.7
10-р хороо	23	33	26	-7	-21.2	1.5
11-р хороо	16	32	40	8	25	2.3
12-р хороо	51	37	66	29	78.4	3.7
13-р хороо	22	22	41	19	86.4	2.3
14-р хороо	39	47	44	-3	-6.4	2.5
15-р хороо	31	23	37	14	60.9	2.1
16-р хороо	30	32	46	14	43.8	2.6
17-р хороо	31	38	34	-4	-10.5	1.9
18-р хороо	50	53	55	2	3.8	3.1
19-р хороо	82	94	77	-17	-18.1	4.4
20-р хороо	53	69	85	16	23.2	4.8
21-р хороо	47	29	39	10	34.5	2.2
22-р хороо	26	27	39	12	44.4	2.2
23-р хороо	12	14	17	3	21.4	1.0
24-р хороо	34	14	34	20	2.4[1]	1.9
25-р хороо	11	24	42	18	75	2.4
26-р хороо	23	41	35	-6	-14.6	2.0
27-р хороо	54	65	82	17	26.2	4.6
28-р хороо	20	26	23	-3	-11.5	1.3
29-р хороо	93	59	103	44	74.6	5.8
30-р хороо	15	11	15	4	36.4	0.8
31-р хороо	16	19	19	0	-	1.1
32-р хороо	56	97	74	-23	-23.7	4.2
33-р хороо	61	74	80	6	8.1	4.5
34-р хороо	36	46	54	8	17.4	3.1
35-р хороо	8	5	16	11	3.2[1]	0.9
36-р хороо	22	35	36	1	2.9	2.0
37-р хороо	54	48	50	2	4.2	2.8
38-р хороо	19	20	28	8	40	1.6
39-р хороо	15	9	11	2	22.2	0.6
40-р хороо	30	23	28	5	21.7	1.6
41-р хороо	24	21	23	2	9.5	1.3
42-р хороо	20	8	15	7	87.5	0.8
43-р хороо	15	9	13	4	44.4	0.7
Дүүргийн дүн	**1 470**	**1445**	**1 770**	**325**	**22.5**	**100.0**

[1]-дахин их

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

ДҮҮРГИЙН ТӨСӨВ

2025 оны эхний 4 сард, тэрбум төгрөгөөр



Төсвийн орлогын бүтэц



Татварын орлогын бүтэц







ДҮҮРГИЙН ТӨСӨВ

I-IV/2025 Тархаасан: 2025 оны 5 дугаар сарын 15

Дүүргийн төсвийн нийт орлого 2025 оны эхний 4 сард 48672.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 11735.2 (19.4%) сая төгрөгөөр дутуу бүрдэж

ХҮСНЭГТ 9. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2025 ОНЫ ЭХНИЙ 4 САРД

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2025* I-IV / 2024 I-IV	
	сая төгрөг		Дүн	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	60 407.4	48 672.2	-11 735.2	- 19.4
Татварын орлого	57 507.1	47 064.3	-10 442.8	- 18.2
Орлогын албан татвар	47 497.5	38 073.7	-9 423.8	- 19.8
Хувь хүний орлогын албан татвар	47 497.5	38 073.7	-9 423.8	- 19.8
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	27 206.6	24 106.8	-3 099.8	- 11.4
Үйл ажиллагааны орлого	2 750.0	2 616.1	- 133.9	- 4.9
Хөрөнгийн орлого	4 375.0	3 319.7	-1 055.3	- 24.1
Хөрөнгө борлуулсны орлого	2 200.0	2 130.5	- 69.5	- 3.2
Шууд бус орлого	10 965.9	5 900.6	-5 065.3	- 46.2
Хөрөнгийн албан татвар	1 117.1	1 983.6	866.5	77.6
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1 100.0	1 961.8	861.8	78.3
Бууны албан татвар	15.0	15.5	0.5	3.3
Малд ногдуулах албан татвар	2.1	6.3	4.2	3[1]
Бусад татвар, төлбөр, хураамж	8 892.5	7 007.0	-1 885.5	- 21.2
Бусад нийтлэг төлбөр, хураамж	2 754.2	2 411.9	- 342.3	- 12.4
Улсын тэмдэгтийн хураамж	859.4	177.1	- 682.3	- 79.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	18.9	11.6	- 7.3	- 38.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1 875.9	2 223.2	347.3	18.5
Газрын төлбөр	6 134.7	4 584.3	-1 550.4	- 25.3
Байгалийн нөөц ашигласны төлбөр	3.6	10.8	7.2	3[1]
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	3.6	10.8	7.2	3[1]
Татварын бус орлого	2 900.3	1 607.9	-1 292.4	- 44.6
Нийтлэг татварын бус орлого	1 136.3	828.6	- 307.7	- 27.1
Торгуулийн орлого	915.8	618.8	- 297.0	- 32.4
Төсөв байгууллагын өөрийн орлого	70.5	59.4	- 11.1	- 15.7
Бусад орлого	150.0	150.4	0.4	0.3
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1 764.0	779.3	- 984.7	- 55.8
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	1 764.0	779.3	- 984.7	- 55.8

2025 оны эхний 4 сард татварын орлогын хэмжээ 47064.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 10442.2 (18.2%) төгрөгөөр, татварын бус орлого 1607.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1292.4 (44.6%) сая төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн байна. Харин хөрөнгийн албан татвар 1983.6 болж төлөвлөснөөс 866.5 (77.6%) сая төгрөгөөр илүү бүрдүүлсэн байна. Нийт хөрөнгийн албан татварын 1961.8 (98.9%) сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн албан татвар, 15.5 (0.8%) сая төгрөгийг бууны албан татвар, 6.3 (0.3) сая төгрөгийг малд ногдуулах албан татвар тус тус бүрдүүлсэн байнө.

ЗУРАГ 4. **ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ,**
2025 оны эхний 4 сард, сая төгрөг



Төсвийн нийт орлогын 47064.3 (96.7%) сая төгрөгийг татварын орлого, 1607.9 (3.3%) сая төгрөгийг татварын бус оролго тус тус бүрдүүлжээ. Нийт татварын оролгын 38073.7 (78.2%) сая төгрөгийг хувь хүний орлогын албан татвар, 1983.6 (4.1%) сая төгрөгийг хөрөнгийн албан татвар, 8614.9 (17.7%) сая төгрөгийг бусад татвар, төлбөр хураамжаас тус тус бүрдүүлжээ.

ХҮСНЭГТ 10. **ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2025 ОНЫ ЭХНИЙ 4 САРД**

Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2025* I-IV / 2024 I-IV	
	сая төгрөг		Дүн	Хувь
НИЙТ ЗАРЛАГА	**73 192.4**	**47 740.1**	**-25 452.3**	**- 34.8**
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47 682.6	37 869.8	-9 812.8	- 20.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6 956.7	6 348.6	- 608.1	- 8.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	870.4	779.3	- 91.1	- 10.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12 126.6	8 519.0	-3 607.6	- 29.7
Хангамж, бараа материалын зардал	5 307.6	4 725.7	- 581.9	- 11.0
Норматив зардал	38.9	25.3	- 13.6	- 35.0
Эд хогшил, урсгал засварын зардал	2 011.5	881.8	-1 129.7	- 56.2
Томилолт, зочны зардал	165.0	52.3	- 112.7	- 68.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3 338.8	2 218.4	-1 120.4	- 33.6
Бараа үйлчилгээний бусад зардал	16 867.1	14 319.4	-2 547.7	- 15.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7 154.7	6 945.9	- 208.8	- 2.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	6 586.2	6 496.2	- 90.0	- 1.4
Бусад урсгал шилжүүлэг	568.5	449.7	- 118.8	- 20.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18 355.1	2 924.4	-15 430.7	- 84.1

Дүүргийн төсвийн нийт зардал 2025 оны эхний 4 сард 47740.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 25452.3 (34.8%) сая төгрөгийн зардал хэмнэсэн байна. Төсвийн нийт зардлын 37869.8 (79.3%) сая төгрөгийг

бараа, ажил үйлчилгээний зардалд, 6945.9 (14.6%) сая төгрөгийг урсгал шилжүүлэгт, 2924.4 (6.1%) сая төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулжээ. Нийт бараа, ажил үйлчилгээний зардлын 6348.6 (16.8%) сая төгрөгийг цалин хөлс нэмэгдэл урамшуулалд, 779.3 (2.2%) сая төгрөгийг ажил олгогчоос нийгмийн даатгалд, 8519.0 (22.5%) сая төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 4725.7 (12.5%) сая төгрөгийг хангамж, бараа материалын зардалд, 25.3 (0.0.7%) сая төгрөгийг норматив зардалд, 881.8 (2.3%) сая төгрөгийг эд хогшил, урсгал засварын зардалд, 2218.4 (5.9%) сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд, 14319.4 (37.8%) сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд, тус тус зарцуулсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн орлого: Тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар өслөө.

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2025 оны 4 дүгээр сард нийслэлийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 9.8 хувь, өмнөх сараас 0.3 хувиар өссөн байна.

Зураг 5.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Хэрэглээний үнийн индекс 2025 оны 4 дүгээр сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 3.6 хувиар өсөхөд Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 6.0 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис бүлгийн үнэ 3.0 хувь, хувцас бөс бараа гутал бүлгийн үнэ 1.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 3.9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 3.2 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 2.4 хувь, тээвэр бүлгийн үнэ 3.6 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 1.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 7.0 хувиар, даатгал санхүүгийн үйлчилгээ бүлгийн үнэ 6.1 хувиар, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 3.4 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

Хүснэгт 11. **ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр**

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	2024-IV / 2023-IV	2025-IV / 2024-IV	2025-IV / 2024-XII	2025-IV / 2025-III
Ерөнхий индекс	**6.1**	**9.8**	**3.6**	**0.3**
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	7.5	7.1	6.0	0.9
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	4.3	5.7	3.0	0.9
Хувцас, бөс бараа, гутал	4.5	10.7	1.5	0.6
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	5.7	25.8	3.9	1.1
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	5.4	7.5	3.2	-0.2
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	8.1	5.5	2.4	0.3
Тээвэр	-0.3	5.8	3.6	-1.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	2.2	-0.4	0.0	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.9	5.3	1.6	0.4
Боловсролын үйлчилгээ	21.2	20.4	0.0	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	5.1	14.8	7.0	2.4
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	2.3	6.1	6.1	1.7
Бусад бараа, үйлчилгээ	14.1	11.6	3.4	0.1

2025 оны 4 дүгээр сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 417 төрлийн бараа, үйлчилгээний үнийг өмнөх сартай харьцуулахад 39.1 хувь нь өсөж, 25.9 хувь нь буурч, 35.0 хувь нь тогтвортой байв.

Зураг 6. **НЭГ ШИРХЭГ ТАЛХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн IV сард, төгрөг**



Зураг 7. **НЭГ КИЛОГРАММ САВЛАСАН ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн IV сард, төгрөг**



Зураг 8. **НЭГ КИЛОГРАММ ХҮНСНИЙ НОГООНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн IV сард, төгрөг**





Зураг 9. НЭГ ЛИТР ТАРАГ, СҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн IV сард, төгрөг



Хүснэгт 12. НЭГ КИЛОГРАММ МАХНЫ ЖИЖИГЛЭН ХУДАЛДАХ ДОЛОО ХОНОГИЙН ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөг

Үхрийн ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2020	10 524	11 412	11 660	11 735	11 939	12 640	12 758	11 751	11 237	10 684	11 074	11 208
2021	11 614	12 606	12 666	13 853	13 956	14 768	14 793	13 700	13 420	13 277	13 342	13 493
2022	14 059	13 999	14 255	14532	15 144	15 387	15119	14236	13730	13 562	13 226	13 395
2023	13 610	14 416	15 072	16 747	18 476	20 100	19 040	16 436	16 277	15 688	15 542	15 842
2024	16 436	17 149	17 624	18 126	19 531	18 895	18 533	17 735	18 137	17 864	17 783	18 261
2025	19 073	19 637	19 932	20 064								

Хонины ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2020	8 590	9 593	9 763	9 836	10 125	10 385	10 648	9 864	9 169	8 551	8 632	8 579
2021	9 034	10 459	10 692	12 318	12 389	12 696	12 440	11 380	10 974	11 006	10 773	10846
2022	11 530	11 939	12 585	12 620	12 705	12 803	12358	11526	11022	10238	9 806	9 918
2023	10 545	11 721	12 820	14 062	15 369	16 597	15 288	13 237	12 702	12 006	11 834	12078
2024	12 923	13 776	13 917	14 628	16 054	16 355	15 294	14 745	14 510	14 245	14 088	14697
2025	15 560	16 495	17 177	17 458								

2025 оны 4 дүгээр сард хүнсний зах, супермаркет, бөөний төвүүдэд жижиглэн худалдаалагдаж буй үхрийн ястай махны үнэ өмнөх сартай харьцуулахад 0.6 хувиар, хонины ястай махны үнэ 1.6 хувиар тус тус өссөн байна.

Зураг 10. НЭГ КГ ХОНЬ, ҮХРИЙН МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг



Зураг 11. НЭГ ЛИТР ШАТАХУУНЫ ҮНЭ, өөрчлөлт орсон өдрөөр



Хүснэгт 13. ТҮЛШНИЙ ҮНЭ, төгрөг

Байршил	2023.IV.24			2024.IV.29			2025.IV.28		
	Түлшний мод шуудай (6-7 кг)		Сайж-руулсан түлш 25 кг	Түлшний мод шуудай (6-7 кг)		Сайж-руулсан түлш 25 кг	Түлшний мод шуудай (6-7 кг)		Сайж-руулсан түлш 25 кг
	Хар мод	Нарс мод		Нарс мод	Хар мод		Хар мод	Нарс мод	
Чингэлтэй	6 500	6 000	3 750	7 000	7 500	3 750	7 500	7 000	3 750
Сүхбаатар	7 000	6 000	3 750	7 000	7 500	3 750	7 500	7 000	3 750
Цайз зах	7 000	6 000	3 750	7 500	8 500	3 750	8 000	8 000	3 750
Хангай зах	6 000	5 500	3 750	7 000	7 000	3 750	7 000	7 000	3 750
Дундаж үнэ	**6 625**	**5 875**	**3 750**	**7 125**	**7 625**	**3 750**	**7 500**	**7 250**	**3 750**

Хүснэгт 14. НЭГ ЛИТР ШАТАХУУНЫ ҮНЭ, төгрөг

ШТС	2024.IV.29					2025.IV.28				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	-	-	2 390	3 590	-	-	-	2 390	3 140	-
Петровис	3 910	2 370	2 390	3 590	-	3 710	2 370	2 390	3 140	-
Магнай трейд	3 910	-	2 390	3 590	-	3 710	-	2 390	3 140	-
Сод монгол	3 910	2 315	2 390	3 590	-	3 710	2 315	2 390	3 140	-
Шунхлай	3 910	2 350	2 390	3 590	-	3 710	2 350	2 390	3 140	-
Юнигаз	-	-	-	-	1 790	-	-	-	-	1 790
Дундаж үнэ	**3 910**	**2 345**	**2 390**	**3 590**	**1 790**	**3 710**	**2 345**	**2 390**	**3 140**	**1 790**

Зураг 12.

АМ.ДОЛЛАРЫН ХАНШИЙН САРЫН ДУНДАЖ ХӨДӨЛГӨӨН, төгрөг[2]



[2] Эх үүсвэр: Монголбанкны статистикийн мэдээлэл

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томьёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^{L} = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}}\right)\left(\frac{P_{it-1}}{P_{it-2}}\right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}}\right)\left(\frac{P_{i1}}{P_{i0}}\right)\frac{P_{i0}Q_{i0}}{\sum P_{i0}Q_{i0}}$$

I_{ct}^{L} – t тайлант үеийн Ласдейресийн үнийн индекс
t – Тайлант үе
0 – суурь үе
P_t^i – і барааны тайлант үеийн үнэ
P_0^i – і барааны тайлант үеийн үнэ
q_0^i – і барааны тайлант үеийн үнэ

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан.

ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

Нийслэлийн агаарын дундаж хэм 2025 оны 4 дүгээр сард 4.7 ^{0}C байв.

Нийслэлийн агаарын дундаж хэм 2025 оны 4 дүгээр сард 4.7 ^{0}C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.2 ^{0}C-аар хүйтэн, олон жилийн дундажтай харьцуулбал 3.0^{0}C-аар дулаан байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 24.5^{0}C, хамгийн хүйтэн хэм -10.4 ^{0}C, хур тунадасны нийлбэр 0.8 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 19 метр секунд хүрсэн байна.

Хүснэгт 15. **АГААРЫН БОХИРДОЛТ, мг/м3, IV сард**

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO_2	0.050	433	0.116	22	0.022
Азотын давхар исэл	NO_2	0.050	468	0.173	67	0.034
Тоосжилт	PM_{10}	0.100	524	0.590	175	0.096
	$PM_{2.5}$	0.050	515	0.058	2	0.018
Нүүрстөрөгчийн дутуу исэл	CO	10.000	1 307	5.434	1 307	0.787
Озон	O_3	0.100	907	0.132	41	0.038

2025 оны 4 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад хүхэрлэг хий 0.002 мг/м^3, азотын давхар исэл 0.003 мг/м^3 -ээр, нүүрс төрөгчийн дутуу исэл 0.165 мг/м^3 -ээр, PM 2.5 тоосонцор 0.004 мг/м3 -ээр, озон 0.014 мг/м3 -ээр тус тус бага, PM 10 тоосонцор 0.014 мг/м3 -ээр их байна.

Зураг 13. **УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ ХҮХЭРЛЭГ ХИЙН АГУУЛАМЖ, 15 станцын дундаж, мг/м3**



Зураг 14.

УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ АЗОТЫН ДАВХАР ИСЛИЙН АГУУЛАМЖ, 16 станцын дундаж, мг/



Зураг 15.

УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ 10 МИКРОНООС БАГА ХЭМЖЭЭТЭЙ ТООСНЫ АГУУЛАМЖ, 18 станцын дундаж, мг/м3



Хүснэгт 16.

УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАХ БОДИСЫН АГУУЛАМЖ АГААРЫН ЧАНАРЫН СТАНДАРТ ХҮЛЦЭХ АГУУЛАМЖААС ДАВСАН ТОХИОЛДЛЫН ТОО, станц, 2025 оны IV сард

Станцын байршил	Хүхэрлэг хий (SO_2)	Азотын давхар исэл (NO_2)	Нүүрс төрөгчийн дутуу исэл (CO)	Тоосонцор (PM_{10})	Тоосонцор ($PM_{2.5}$)
Нийт	**22**	**67**	**0**	175	2
Мишээл экспо				5	
Баруун 4 зам		18		4	
Тахилт	12	28		19	1
13-р хороолол		6		1	
Зуун айл				10	
Цахилгаан станц		5		26	
Ургах наран хороолол		5		20	1
Хайлааст	3			10	
Таван буудал				19	
Богд хааны ордон музей		3			
Шархад				5	
Налайх				8	
Яармаг				15	
Нисэх				3	
Толгойт	7			9	
Зурагт		2		1	
Амгалан				6	
Дамбадаржаа				14	
Баянхошуу					

Хүснэгт 17. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСЫН ХОНОГИЙН ДУНДАЖ АГУУЛАМЖ, мг/м3, IV сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл Экспо төв	Баруун дөрвөн зам	Тахилт	13-р хороо-лол	Зуун айл	Цахил-гаан станц	Ургах наран хороо-лол	Хай-лааст	Таван буудал
Хүхэрлэгхий SO_2	Дундаж	0.023	0.024	0.042	0.018	0.019	0.011	0.014	0.026	0.025
	Хамгийн их	0.047	0.043	0.096	0.039	0.04	0.022	0.031	0.116	0.048
	ХХХ*-с давсан %	-	-	40	-	-	-	-	11	-
	Хэмжилтийн тоо	29	29	30	30	30	30	30	27	30
Азотын давхар исэл NO_2	Дундаж	0.009	0.052	0.106	0.037	0.012	0.026	0.039	0.024	0.025
	Хамгийн их	0.021	0.079	0.173	0.062	0.023	0.068	0.073	0.036	0.041
	ХХХ*-с давсан %	-	60	97	20	-	17	17	-	-
	Хэмжилтийн тоо	30	30	29	30	30	30	30	27	28
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	0.262	0.826	1.294	0.752	0.667	0.683	0.302	1.204	-
	Хамгийн их	2.19	2.381	5.434	3.472	1.981	2.492	1.109	3.784	-
	ХХХ*-с давсан %	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	83	86	90	90	90	90	90	80	-
Тоос PM_{10}	Дундаж	0.079	0.076	0.121	0.058	0.086	0.25	0.188	0.084	0.116
	Хамгийн их	0.187	0.158	0.224	0.115	0.156	0.59	0.571	0.131	0.248
	ХХХ*-с давсан %	17	13	63	3	33	87	69	36	63
	Хэмжилтийн тоо	30	30	30	30	30	30	29	28	30
Тоос $PM_{2.5}$	Дундаж	0.023	0.018	0.029	0.016	0.014	0.026	0.024	0.021	-
	Хамгийн их	0.045	0.035	0.053	0.037	0.025	0.05	0.058	0.032	-
	ХХХ*-с давсан %	-	-	3	-	-	-	3	-	-
	Хэмжилтийн тоо	30	30	30	30	30	30	30	28	-
Озон $O3$**	Дундаж	0.041	-	-	0.019	0.013	-	0.01	-	-
	Хамгийн их	0.069	-	-	0.036	0.023	-	0.017	-	-
	ХХХ*-с давсан %	-	-	-	-	-	-	0	-	-
	Хэмжилтийн тоо	89	-	-	90	90	-	80	-	-

үргэлжлэл

Агаарын бохирдлын үзүүлэлт		Богд хааны ордон музей	Шар-хад	Налайх	Яармаг	Нисэх	Толгойт	Зураг	Амга-лан	Баян-хошуу
Хүхэрлэгхий SO_2	Дундаж	0.021	0.015	0.017	0.025	-	0.036	-	-	0.018
	Хамгийн их	0.044	0.032	0.039	0.049	-	0.079	-	-	0.033
	ХХХ*-с давсан %	-	-	-	-	-	23	-	-	-
	Хэмжилтийн тоо	25	27	30	30	-	30	-	-	26
Азотын давхар исэл NO_2	Дундаж	0.036	0.037	0.024	0.031	-	0.024	0.032	0.027	-
	Хамгийн их	0.057	0.047	0.041	0.049	-	0.043	0.053	0.045	-
	ХХХ*-с давсан %	11	-	-	-	-	-	7	-	-
	Хэмжилтийн тоо	28	30	30	30	-	30	26	30	-
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	0.375	0.822	0.627	0.778	0.573	1.29	1.344	-	-
	Хамгийн их	0.916	5.02	2.238	2.9	1.559	4.767	5.103	-	-
	ХХХ*-с давсан %	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	84	90	90	87	90	88	79	-	-
Тоос PM_{10}	Дундаж	0.048	0.069	0.084	0.094	0.066	0.079	0.057	0.062	-
	Хамгийн их	0.087	0.13	0.164	0.194	0.109	0.145	0.102	0.16	-
	ХХХ*-с давсан %	-	17	27	50	10	31	4	22	-
	Хэмжилтийн тоо	28	30	30	30	30	29	26	27	-
Тоос $PM_{2.5}$	Дундаж	0.008	0.011	0.011	0.007	0.017	0.023	0.023	0.013	0.022
	Хамгийн их	0.034	0.028	0.025	0.032	0.027	0.039	0.044	0.039	0.035
	ХХХ*-с давсан %	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	28	30	23	30	30	29	26	27	25
Озон $O3$**	Дундаж	-	0.014	0.001	0.049	0.065	0.08	0.063	0.068	-
	Хамгийн их	-	0.021	0.004	0.095	0.121	0.132	0.107	0.116	-
	ХХХ*-с давсан %	-	-	-	-	8	30	5	5	-
	Хэмжилтийн тоо	-	44	90	87	88	87	76	86	-

Туул голын усны бохирдол:

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2025 оны 4 дүгээр сарын 12 - 13-ны өдөр хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд Амоны азот 23.5 дахин, Эрдэс фосфор 6.0 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 17.9 дахин хүлцэх хэмжээнээс давж Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

НИЙСЛЭЛИЙН ГАДАРГЫН УСНЫ НАЙРЛАГА, мг/м3, IV сард

Хүснэгт 18.

Үзүүлэлт		Стандарт хэмжээ	"Туул-Налайх" харуул цэг		"Туул-Сонгино доод" харуул цэг	
			Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч	O_2	≥6	10.97	Хэвийн	6.04	хэвийн
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	$БХХ_5$	≤3	2.7	Хэвийн	53.7	17.9 дахин
Нитритийн нэгдэл	NO_2	≤0.02	0.007	Хэвийн	0.319	16.0 дахин
Амоны азот	NH_4	≤0.5	0.07	Хэвийн	11.78	23.5 дахин
Эрдэс фосфор	P	≤0.1	0.016	Хэвийн	0.603	6.0 дахин

Байгаль орчны зөрчил:

Нийслэлийн хэмжээнд 2025 оны эхний 4 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 411 зөрчлийг илрүүлжээ. Илрүүлсэн нийт зөрчлийн 81.5 хувийг ан амьтны зөрчил, 11.7 хувийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, 2.2 хувийг усны зөрчил, 1.7 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 1.0 хувийг ургамал хөрсний бохирдолын зөрчил, 0.5 хувийг ойн зөрчил, 0.2 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 1.2 хувийг бусад зөрчил эзэлж байна. Илрүүлсэн нийт зөрчилд 84.6 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗӨРЧИЛ, төрлөөр

Хүснэгт 19.

Илрүүлсэн зөрчил, Төрлөөр	2025 I-IV		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая төгрөг)
Бүгд	**417**	**411**	**84.6**
Ой	3	2	
Ан, амьтан	338	335	21.3
Газрын	-	-	-
Ус	9	9	24.0
Ургамал, хөрсний бохирдол	4	4	0.1
Агаар, химийн хорт бодис	1	1	-
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	7	7	5.3
Геодези зураг зүй, кадастр	-	-	-
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	48	48	32.8
Бусад	7	5	1.1

Аюулт үзэгдэл, осол:

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2025 оны эхний 4 сард 57 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 55.1 хувиар буурсан байна. Гамшгийн улмаас 10 хүн амь насаа алдаж, 63 хүнийг аварч, гамшгийн уршгийг арилгах ажилд нийт 1281.2 сая төгрөг зарцуулжээ.

Хүснэгт 20. ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, дүүргээр, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Дүүрэг	2020 I-IV	2021 I-IV	2022 I-IV	2023 I-IV	2024 I-IV	2025 I-IV	2025/2024 Хувь
Нийслэлийн дүн	**864**	**617**	**798**	**607**	**582**	**1 033**	**77.5**
Багануур	13	11	9	7	12	46	3.8**
Багахангай	3	-	3	2	3	6	2.0**
Баянгол	101	68	78	64	50	94	88.0
Баянзүрх	194	150	215	155	157	230	46.5
Налайх	23	18	19	19	28	49	75.0
Сонгинохайрхан	231	149	202	148	139	265	90.6
Сүхбаатар	120	81	107	88	67	109	62.7
Хан-Уул	83	67	91	60	67	147	2.2**
Чингэлтэй	96	73	74	64	59	87	77.5

2025 оны эхний 4 сард ахуйн 1033 гал түймэр гарч өмнөх оны мөн үеэс 77.5 хувиар нэмэгдсэн байна. Гал түймрийн улмаас 16 хүн түлэгдэж гэмтэн, 8 хүн эндсэн байна. Худал дуудлага 19 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.1 дахин их байна.

Гал түймрийн аюулаас 1569 хүн, 261 байшин барилга, 138.7 сая төгрөгийн эд хөрөнгийг аварсан байна. Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал санамсаргүй байдлаас 749 (72.5%), цахилгаанаас 255 (24.7%), санаатай үйлдлээр 3 (0.3%), бусад шалтгаанаар 26 (2.5%) гал түймэр гарчээ.

Зураг 16. ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, байршлаар, эзлэх хувь



Гал түймэрт 440 гэр, орон сууц, 49 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 48 машин техник, 125 малын хашаа саравч, бусад төрлийн 371 объект өртжээ. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 689, төрийн өмчийн 252, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 92 объект өртөж, нийт 1941.9 сая төгрөгийн хохирол учирсан байна.Нийслэлийн Онцгой байдлын газраас 2025 оны эхний 4 сард 125 барилгын зураг төсөл, ашиглалтад хүлээн авч буй 181 барилгад хяналт тавьж ажиллажээ. Түүнчлэн 2026 объектод үзлэг шалгалт хийж, 8912 галын зөрчил илрүүлж, байгууллага, албан тушаалтан, иргэнд 465 заавал биелүүлэх албан шаардлага, 924 мэдэгдэл хүргүүлж, 127.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол*:* Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл*:* Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг*:* Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин*:* Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.

Танилцуулгыг хянасан:

Б.Баатарцогт

Г.Батцэцэг

Танилцуулгыг бэлтгэсэн:

Г.Батцэцэг	Дүүргийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлт
О.Үүрийнцолмон	Эрүүл мэнд
	Хэрэглээний үнэ
С.Удвал	Гэмт хэрэг
	Цаг уур, агаарын чанар, аюулт үзэгдэл, осол
	Дүүргийн төсөв

Танилцуулгыг нэгтгэсэн:

С.Удвал

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ХОЛБОО БАРИХ:
Утас: 70171660, 70171322
E-mail: Songinokhairkhan@nso.mn